



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 5/19

Чингис хот

Б.Дарханбаатарыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилаал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоо тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн Баатарцогтын Дарханбаатарыг Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалд 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Дарханбаатарын цалинг Т3-10-3 шатлалаар тогтоон үндсэн цалин 981742 /есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5, зэрэг дэвийн нэмэгдлийг 18 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Дарханбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР



231030088